



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн “Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн иргэдэд эзэмшүүлсэн хувьцаа, түүнд хуваарилагдсан ногдол ашгийг өвлөгчид шилжүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (М.Энхсайхан), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (Б.Даваадалай), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Н.Цэрэнсамбуу)-д, уг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Давааням)-т даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Т.Жамбаажамц)-нд зөвлөсүгэй.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээний талаар иргэдэд нэгдсэн ойлголт, мэдээлэл өгч, ач холбогдлыг таниулах, сурталчлах болон холбогдох байгууллага хооронд хууль тогтоомжийн дагуу харилцан мэдээлэл солилцох, иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Давааням), “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (М.Энхсайхан), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (Б.Даваадалай), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Н.Цэрэнсамбуу)-д тус тус даалгаж, Монголын нотариатчдын танхим (Л.Буддорж), Санхүүгийн зохицуулах хороо (Т.Жамбаажамц)-нд тус тус зөвлөсүгэй.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжүүдэд худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 350 дугаар тогтоолын 2.3 дахь заалтын “зах зээл нээгдэх хүртэл” гэсний дараа “өвлүүлэхээс бусад байдлаар” гэж, ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны тухай” Засгийн газрын 2012 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 3 дахь заалтын “саналын эрхгүй,” гэсний дараа “өвлүүлэх болон” гэж тус тус нэмсүгэй.

4.Энэ тогтоолын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажлын явц, үр дүнг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж

ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (Б.Даваадалай), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Н.Цэрэнсамбуу)-д тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ЭНХБАЯР